БАТЛАВ:

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ОТГОНДУЛАМ

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

3. **Барааны тодорхойлолт: “ ДОТУУР БАЙР“-ны** хүнсний нийлүүлэлт

4. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүсэл улсын зохих стандартад нийцсэн байна.*

3. Баглаа, боодол: Стандартын шаардлага хангасан баглаа боодолтой байна.

4.Бараа хүргэх газар: Хэнтий аймаг Цэнхэрмандал сумын ЕБСургууль

5.Бараа нийлүүлэлтийн хуваарь: Барааг тогтмол өдөр болгон жижиглэнгээр авах ба хоолны цэс үндэслэн урьдчилан захиалгаа 7 хоногийн өмнө өгнө.

6. **Нийт үнэ:** 57.968.000төгрөг

2. **Барааны тодорхойлолт:**

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
Багц 1	**Мах махан бүтээгдэхүүний багц / үхэр, хонь, цувдай, тахианы мах /**	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.7, 10.1.9 дэхь заалтыг хэрэгжүүлж хангасан байна. **1.2. Барааны нэр: Үхэр, хонь,** Нийлүүлэгдэх мах нь: • Мах нь шинэ чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, хөлдөөсөн, гадаргуу цэвэр, гадны үнэр амт байхгүй байна. / шивтэр, бензин г м / • Шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна. • Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгсэлийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. **1.2.Барааны нэр: Тахианы мах** • Мах нь шинэ чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, хөлдөөсөн, гадаргуу цэвэр, гадны үнэр амт байхгүй байна. Бэлтгэсэн он сар өдөр, хадгалах хугацааг / шивтэр, бензин г м /

		• Шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна. **1.3.Барааны нэр: Цувдай** • Цувдай нь шинэ, цэвэрлэсэн, хөлдүү биш гадны үнэр амтгүй байна. / шивтэр, бензин г м / • Шинжилгээний бичигтэй байна.
Багц 2	**Талх, нарийн боовны багц**	Шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Шинжилгээний бичигтэй байна. **2.1. Барааны нэр: Талх** • Чийгээ алдаагүй шинэ талх байна • Талхны хэмжээ 800 граммаас багагүй байна. • Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.7, 10.1.9, 12.1, 12.4 дэх заалтыг хэрэгжүүлж хангасан байна. **2.2. Барааны нэр: Нарийн боов** • Хэлбэр дүрсээ алдаагүй, өнгө үзэмж сайтай шинэ байна. • Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн эрүүл хүнс байна. / аминдэм, ккал нь стандартын норм хангасан / • Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.9, 10.1.10, 12.1, 12.4 дэх заалтыг хэрэгжүүлж хангасан байна. **.3 Барааны нэр: Жигнэмэг** • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна.
Багц 3	**Хүнсний ногооны багц:**	**Ерөнхий зүйл** Нийлүүлэгдэх ногоо нь: орон нутагт тариалагдсан байна. Шинжилгээний бичигтэй байна. • Хорхойд идэгдээгүй байх • 2012 оны " Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль "-ийг хэрэгжүүлсэн байна. **3.1. Барааны нэр: Төмс** • Төмсний диаметр 6-7 багагүй, 1 ш төмсний дундаж жин 180-250 гр байх • Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. / гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх / • Монгол үрийн төмсөөр тарьсан байх **3.2. Барааны нэр: Байцаа, улаан байцаа**

		• Байцаа нь хөвсгөр , муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй, ялзраагүй байх • Байцааны дундаж жин нь 1.5-2 кг байна • Гадаргууны илүүдэл навч, голыг цэвэрлэсэн байна. **3.3. Барааны нэр: Бөөрөнхий сонгино** • Ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. • Соёолж хөгшрөөгүй байхаас гадна 1ш сонгины дундаж жин 100-150 гр байна **3.4. Барааны нэр: Лууван** • 1 ш луувангийн дундаж жин 200-300 гр байх ба механик элдэв хольцгүй , зөөлөрч муудаагүй, чийгээ алдаагүй, соёолоогүй, гадны үнэр амтгүй байна. • Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар, чихэрлэг амттай, улбар шар өнгөтэй байна. **3.5. Барааны нэр: Хүрэн манжин, шар манжин** • Хүрэн манжингийн дундаж жин 250-350 гр байх ба зөөлөрч муудаагүй чийгээ алдаагүй, соёолоогүй байна. • Гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй, шинэ байна. • Гадаргууны шороо, үндэс, навчыг бүрэн цэвэрлэсэн байна. **3.6. Барааны нэр: Хатаасан сонгино, хар мөөг** • Хугацаа хэтрээгүй / савласан он сар өдөр тодорхой байна./ • Муудайгүй, элдэв механик хольцгүй байна. **3.7. Барааны нэр: Сармис** • Ялзарч муудаж гэмтээгүй , хөгшрөөгүй, хатаж чийгээ алдаагүй шинэ байна. • Орон нутагт тариалсан байна. **3.8. Барааны нэр: Нарийн ногоо / өргөст хэмх, чинжүү, улаан лооль, хулуу /** • Шинэ байна. • Гэмтэж муудаагүй, хөгцрөөгүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.

		3.9. Барааны нэр: Нарийн ногоо / урт байцаа, цэцэгт байцаа, шөлний байцаа, далайн байцаа, юуцай, бууцай, брокли, салад навч / • Шинэ байна. • Гэмтэж муудаагүй, хөгцрөөгүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1, дэх заалтыг хэрэгжүүлсэн байна.
Багц 4	**Сүү сүүн бүтээгдэхүүний багц**	**Ерөнхий зүйл** Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь: • " Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль "-ийг хэрэгжүүлсэн байна. • Зориулалтын саваар тээвэрлэнэ. • Шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна. • Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ үнэ зэргийг тусгасан байна. • Нийлүүлэгдэх сүү сүүн бүтээгдэхүүн нь эх орны бүтээгдэхүүн байна. **4.1.Барааны нэр: Шингэн сүү:** • Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна. • Гадны үнэр амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ, шингэн болон хөлдөөсөн байна. • Тээвэрлэлтийн горимыг баримтална. **4.2. Барааны нэр: Ээзгий** • Монгол аргаар бэлтгэсэн байна. • Стандартын шаардлага хангасан байна. Хэт хатаасан биш, хөгцөрөөгүй, шаргал өнгөтэй байна. • Задгай ээзгийг 1кг-аас дээш савласан байна. **4.3. Барааны нэр: Тараг** • Монгол аргаар бэлтгэсэн байна. • Стандартын шаардлага хангасан байна. • Шинэ, исээгүй, хэт шингэн биш байна. • Задгай тараг нь эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна. **4.4. Барааны нэр: Аарц** • Монгол аргаар бэлтэгдсэн , стандартын шаардлага хангасан байна./ хог хаягдал, шавьж хорхойгүй /

		• Хэт исгэлэн, гашуун, ахарсан, хөгцөрсөн биш байна. • Аарц нь 30кг-аас дээшгүйгээр савлагдсан хөлдүү байна. **4.5. Барааны нэр: Ааруул** • Монгол аргаар бэлтгэгдсэн ./ хөгцөрч муудаагүй / • Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн эрүүл хүнс байна. / аминдэм, ккал нь стандартын норм хангасан / **4.6. Барааны нэр: Масло, зөөхий, цөцгийн тос** Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн эрүүл хүнс байна. / аминдэм, ккал нь стандартын норм хангасан / • Тослогийн хэмжээ 82%-аас багагүй байна. • Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. / элдэв, өнгө, амт, үнэргүй байна.
Багц 5	**Жимс жимсгэний багц:**	**Ерөнхий зүйл:** • Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ. • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна. • Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. • Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна. Лабораторийн шинжилгээний бичигтэй байна. **5.1. Барааны нэр: Хатаасан болон шинэ жимс / үзэм, чавга, чангаанз, алим, хар чавга, мадирин, киви, банана, усан үзэм, лийр, нимбэг, /** • Стандартын шаардлага хаңгасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • Зориулалтын сав баглаанд савласан байна. • Эрүүл, ахуйн шаардлага хангасан байна. / элдэв, өнгө амт үнэргүй, хатаж хорчийгоогүй, хөгцгүй, шороо чулуугүй, хог хаягдалгүй дээд зэргийн чанарынх байна. / • Шинэ жимс нь исэгүй , няцраагүй, хорхой идээгүй, хөгцрөөгүй, иш навчгүй байна. • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна

		5.2. Барааны нэр:Жимс / чацаргана, нохойн хошуу, аньс, нэрс / • Орон нутагт ургасан жимс байна. • Намар, өвлийн улиралд авна. **5.3. Барааны нэр: Варень** • Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна. • Лабораторийн шинжилгээний бичигтэй байна.
Багц 6	**Үр тарианы багц:**	**Ерөнхий зүйл:** • Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна. • Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна. • Лабораторийн шинжилгээний бичигтэй байна. **6.1. Барааны нэр: 1-р, 2-р гурил, бүхэл үрийн гурил** • MNS0244 техникийн шаардлага хангасан байна. • Гадны механик хольцгүй ба үнэр, амтгүй, хөгцөрч муудаагүй байна. • Чийгээ алдаагүй шинэ байна. **6.2. Барааны нэр: Гоймон / лапша , дун гоймон /** • Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна. • 0,35-5 кг-аар савлагдсан чийг аваагүй хуурай, хөгцөрч муудаагүй, үүрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй шинэ байна. • Өндөгний хольцтой, урсамтгай биш шинж чанартай , нарийн хэрчилттэй байна. **6.3. Барааны нэр: Хүүхдийн будаа**

		• MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна. • Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй Байна Алтан тариа- ХХК-ийн будаа байна **6.4. Барааны нэр: Будааны төрөл / цагаан, шар, хөц, гурвалжин, будаа /** • MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна. • Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй , бяцарч хуваагдаагүй байна. • Цагаан будаа нь том ширхэгтэй , агшаахад нялцайхгүй байна. **6.5. Барааны нэр: Лентил, овьёос хэмхдэс,** • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1, 12.4 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлсэн байна.
Багц 7	**Бусад :**	**7.1. Барааны нэр: Давс / бор давс, цагаан давс/** • 0,5-1 кг-аар савлагдсан, чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, иодын агууламж нь зохих түвшинд байна. **7.2. Барааны нэр: Ургамлын тос,** • Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна. • Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. / элдэв, өнгө, амт, үнэргүй байна. **7.3. Барааны нэр:.Исгэгч, цагаан гаа, ванилин, шөлний байцаа, сода, дүпү** • Шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • "Хүнсний хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна. **7.4. Барааны нэр:.Молоко, сок, эрдэнэ шиш, вандуй, зөгийн бал** • Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • Зориулалтын сав баглаанд савласан байна. / сав нь гэмтэж хагараагүй байх / • Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. / элдэв өнгө, амт үнэргүй, монголд үйлдвэрлэгдсэн байна. / **7.5. Барааны нэр: Сахар :**

		• MNS0244:1999 техникийн шаардлага хангасан байна. • Гадны үнэр амтгүй, механик хольцгүй байна. • Чийг аваагүй хуурай, бөөгнөрч хатуураагүй, шарлаагүй, нарийн ширхэгтэй байна. **7.6. Барааны нэр: Өндөг** • Тухайн өдрийн шинэ өндөг байна. • Шинжилгээний бичигтэй байна. Зориулалтын сав, баглаа боодолтой байна. **7.7. Барааны нэр: Цайны хийц, цай, цайны идээ** • Шаардлага хангасан хөгц амтгүй үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. • Зориулалтын сав баглаанд савласан байна. • "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлсэн байна.

Ерөнхий шаардлага:

Багц 1: Мах "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"-ийн 5.1.5, 10.1.7, 10.1.9, 12.1, 12.4 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлсэн байна.

Багц 2: Талх нарийн боовыг зориулалтын машинаар тээвэрлэх ба тус тусад нь савлаж битүүмжилсэн байна.

Багц 3: Хүнсний ногоо тус тусдаа савлагдсан , гадны шороо чулууны хольцгүй байх

Багц 4: Сүүн бүтээгдэхүүнийг зориулалтын таглаатай ариутгасан саванд савлаж тээвэрлэх ба гашилж муудахаас хамгаалах

Багц 5: Эрүүл ахуйн шаардлага хангасан шинэ жимс байна.

Багц 6: Хуурай хүнсний багцад орсон бүтээгдэхүүн тус бүр зориулалтын саванд савлагдсан байх ба гадны тоос шороо орохоос сэргийлсэн, хадгалах хугацаа нь тодорхой заагдсан, тээвэрлэлтий явцад гэмтэж муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байна.

Багц 7: Бусад хүнсний багцанд байгаа зүйлийн хоол амтлагч зориулалтын саванд савалсан байх хугацаа нь тодорхой заагдсан байна.